

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2024/08/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитор: Н.Отгонцэцэг Утас: 70378845 Цахим хаяг: otgontsetsegn@audit.gov.mn
Дархан-Уул аймаг 2024 он	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТОРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бүжгийн гудамж-1,14 дугаар багц Дархан сум,
Дархан-Уул аймаг 45259,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3088
Цахим шуудан: sakhlalshv@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Debt of U № *AB*

төлий _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус байгууллагын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 1 дүгээр тогтоолын хүрээнд "Entcredit инвестмент" ББСБ-тай хамтран санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 321 иргэнд 165,400.0 мянган төгрөгийн хүүгүй, барьцаагүй зээлийг "Финтек" аппликейшнээр олгосныг санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/43 тоот тушаалаар "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээ"-г нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний зардлыг өмнөх оноос 321,213.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилтын хүрээнд 94 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 95.5 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,574,003,309.00</u>	<u>2,276,590,585.00</u>
33	АВЛАГА	1,574,003,309.00	2,276,590,585.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	7,977,550.00	314,332,016.00
335	Бусад авлага	1,566,025,759.00	1,962,258,569.00
3351	Байгууллагаас авах авлага		
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,566,025,759.00	1,962,258,569.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,574,003,309.00</u>	<u>2,276,590,585.00</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,574,003,309.00</u>	<u>2,276,590,585.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,574,003,309.00	2,276,590,585.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,574,003,309.00	2,276,590,585.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,311,174,946.00	1,566,025,759.00
51220	Тайлант үеийн үр дүн	262,828,363.00	710,564,826.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,574,003,309.00</u>	<u>2,276,590,585.00</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,712,683,079.12	1,963,546,000.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,090,079.12	1,812,616,000.00	
120	Нийтлэг татварын бус орлого	57,090,079.12	1,812,616,000.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	57,090,079.12	1,812,616,000.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	650,824,200.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	57,090,079.12	220,797,000.00	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	940,994,800.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,655,593,000.00	150,930,000.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	137,930,000.00	
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	137,930,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,655,593,000.00	13,000,000.00	
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000,000.00	-	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,555,593,000.00	5,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	8,000,000.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,449,854,716.12	1,252,981,174.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,449,854,716.12	1,252,981,174.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,850,000.00	97,558,237.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,850,000.00	92,558,237.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,850,000.00	92,558,237.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,000,000.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,000,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,447,004,716.12	1,155,422,937.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	451,376,244.00	529,267,468.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	451,376,244.00	529,267,468.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	382,331,416.00	-	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,964,660.00	-	
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	369,366,756.00		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	59,090,079.12	81,740,000.00	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,090,079.12	73,740,000.00	
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	2,000,000.00	8,000,000.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	554,206,977.00	544,415,469.00	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	554,206,977.00	544,415,469.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	262,828,363.00	710,564,826.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-	

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,727,647,739.12</u>	<u>1,963,546,000.00</u>	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,054,739.12	1,812,616,000.00	
120	Нийтлэг татварын бус орлого	70,054,739.12	1,812,616,000.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,054,739.12	1,812,616,000.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	650,824,200.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	57,090,079.12	220,797,000.00	
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	12,964,660.00	940,994,800.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,657,593,000.00	150,930,000.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,000,000.00	137,930,000.00	
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	137,930,000.00	
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	2,000,000.00	-	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,655,593,000.00	13,000,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсанхөрөнгө	100,000,000.00	-	
131104	Дээд шатны төсвийн захирагч төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,555,593,000.00	5,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	8,000,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,289,832,266.12</u>	<u>2,531,313,190.00</u>	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,289,832,266.12	2,531,313,190.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,122,200.00	97,558,237.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,122,200.00	92,558,237.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,122,200.00	92,558,237.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,000,000.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,000,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,286,710,066.12	2,433,754,953.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,283,104,044.00	1,493,267,468.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,283,104,044.00	1,493,267,468.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	382,331,416.00	298,980,295.00	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,964,660.00	298,980,295.00	
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	369,366,756.00		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	59,090,079.12	81,740,000.00	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,090,079.12	73,740,000.00	
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	2,000,000.00	8,000,000.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	562,184,527.00	559,767,190.00	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	562,184,527.00	559,767,190.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(562,184,527.00)</u>	<u>(567,767,190.00)</u>	
14	Бусад эх үүсвэр	562,184,527.00	567,767,190.00	
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	562,184,527.00	567,767,190.00	
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>562,184,527.00</u>	<u>567,767,190.00</u>	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,311,304,946.00	1,311,304,946.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(130,000.00)	(130,000.00)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,311,174,946.00	1,311,174,946.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	262,828,363.00	262,828,363.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,574,003,309.00	1,574,003,309.00
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	1,574,003,309.00	1,574,003,309.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(7,977,550.00)	(7,977,550.00)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,566,025,759.00	1,566,025,759.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	710,564,826.00	710,564,826.00
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,276,590,585.00	2,276,590,585.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,916,806,000.00	1,617,825,705.00	(298,980,295.00)	84.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,916,806,000.00	1,617,825,705.00	(298,980,295.00)	84.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	117,250,000.00	92,558,237.00	(24,691,763.00)	78.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	117,250,000.00	92,558,237.00	(24,691,763.00)	78.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	117,250,000.00	92,558,237.00	(24,691,763.00)	78.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,799,556,000.00	1,525,267,468.00	(274,288,532.00)	84.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,759,556,000.00	1,485,267,468.00	(274,288,532.00)	84.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,759,556,000.00	1,485,267,468.00	(274,288,532.00)	84.4
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,000,000.00	40,000,000.00	-	100.0
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	40,000,000.00	40,000,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,916,806,000.00	1,651,565,705.00	(265,240,295.00)	86.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,876,806,000.00	1,577,825,705.00	(298,980,295.00)	84.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,876,806,000.00	1,577,825,705.00	(298,980,295.00)	84.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	40,000,000.00	73,740,000.00	33,740,000.00	184.4
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,000,000.00	73,740,000.00	33,740,000.00	184.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/
		Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	5,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,000,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нэр данс зөрүүтэй гүйлгээнд тусгагдсан 300.0 мянган төгрөгийн орлогыг зээлийн эргэн төлөлтийн орлогоор бүртгээгүй алдаа¹ илэрсэн нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул зээлийн эргэн төлөлтийн орлогоор бүртгүүлж залруулав.

Мөн аудитаар нийт 5,570.0 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрснийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа, зөрчил илрээгүй болно.

3.2 Албан шаардлага

Аудитаар төлбөрийн албан шаардлага өгөх алдаа, зөрчил илрээгүй болно.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант оны эхний хагас жилд хөдөлмөр эрхлэлтийг бэлтгэх сургалтад хамрагдсан ажил олоход хүндрэлтэй 25 иргэний 5,250.0 мянган төгрөгийн хоол, унааны мөнгийг сургалтад хамрагдах хугацаанд олгоогүй нь Төсвийн тухай хуулийн 16.5.5, НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16.5.5, НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтуудыг баримталж, “ажил олоход хүндрэлтэй иргэдэд хоол, унааны мөнгийг олгохдоо сургалтад хамрагдах хугацаанд нь олгох”

1.2. Илрүүлэлт:

Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны зохион байгуулсан сургалтад хамрагдсан иргэдийн анхан шатны баримт, мэдээлэл хангалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.5, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 13.7 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16.5.5, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 13.7 дахь заалтуудыг баримталж “Сургалт зохион байгуулсан гэрээ дүгнэсэн акт, анхан шатны баримт, холбогдох албан тушаалтан дүгнэлтэд үндэслэн зардлыг санхүүжүүлэх, ажил гүйлгээг бүртгэх”

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Зээлийн эргэн төлөлт 300,000.00 төгрөгийн орлогыг нэр данс зөрүүтэй орлогоор бүртгэсэн байна.	1	300.0	-	-	1	300.0	1	300.0	-	-	-	-
Дүн	1	300.0	-	-	1	300.0	1	300.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
							Тоо	Дүн				
Тайлант оны эхний хагас жилд хөдөлмөр эрхлэлтийг бэлтгэх сургалтад хамрагдсан ажил олоход хүндрэлтэй 25 иргэний 5,250.0 мянган төгрөгийн хоол, унааны мөнгийг сургалтад хамрагдах хугацаанд нь олгоогүй байна.	1	5,250.0	-	-	-	-	1	5,250.0	-	-	-	-
Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны зохион байгуулсан сургалтад хамрагдсан иргэдийн анхан шатны баримт, мэдээлэл хангалтгүй байна.	1	320.0	-	-	-	-	1	320.0	-	-	-	-
Дүн	2	5,570.0	-	-	-	-	2	5,570.0	-	-	-	-